



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛААР
БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГТ “МАРШАЛЫН АЛБАНЫ” ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН
ХҮРГҮҮЛСЭН САНАЛ**

НАВААНЫ ГАНТУЛГА

ШШГС-ийн захирал, доктор /Ph.D/,
дэд профессор, хурандаа

2012.12.20

Хүний эрх, эрх чөлөөг бодит утгаар нь дээдлэн хэрэгжүүлэгч эрх зүйт /ёсыг/ төрийг төлөвшүүлэх их үйлс, шинэчлэлийн Засгийн газрын бодлогын хүрээнд хийгдэж буй хуулийн төслүүдийг нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гарган боловсруулж байгаа хуульч-судлаачдын багт юуны өмнө талархал илэрхийлж ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хурлын зааланд 2012 оны 12-р сарын 19-ны өдөр шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын ажилтан, судлаачдын хүрээнд зохион байгуулагдсан багц хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт оролцогчийн хувьд тухайн үед “Маршалын албаны тухай” хуулийн төслийн агуулгатай холбогдуулан гаргасан саналаа уншигч та бүхэнд хүргэж байна. Үүнд:

1. Олон улсын нийтлэг жишиг, практикаас үзвэл Маршалын албаны чиг үүрэгт төсөлд дурьдсанаас гадна “хорих ял эдлэгдсийг /ялтан/ олон улсын гэрээний дагуу шилжүүлэх ажиллагааны бие даасан хэсэг болох хуяглан хүргэх асуудал” хамаардаг тул төслийн 6-р зүйлийн 6.6-р хэсэгт энэ чиг үүргийг нэмж оруулах.

2. Төслийн 5-р зүйлийн 5.1-д “Маршалын алба нь хуульд заасан шүүхийн тодорхой төрлийн шийдвэр болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий хараат бус, бие даасан, **төрийн тусгай байгууллага** мөн” хэмээн заажээ.

Өнөөдөр мөрдөгдөж буй монгол улсын хууль тогтоомжид төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудыг ихэвчлэн “...үүрэг бүхий төрийн байгууллага¹”, “...төрийн захиргааны байгууллага²”, “... хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага³” хэмээн хуульчилсан байна. Иймд төсөлд “...төрийн тусгай байгууллага” гэхээс илүү “...хууль сахиулах байгууллага” хэмээн томъёолж болох юм.

3. Төслийн 19-р зүйлийн 19.4-д “Тав ба түүнээс дээш жил хорих ялаар

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн. // Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5-р зүйлийн 5.1 хэсэг

² Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. //Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1 хэсэг.

³ Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн. // Прокурорын байгууллагын тухай хуулийн 2-р зүйлийн 2.1 хэсэг



шийтгэгдсэн болон оргож болзошгүй шүүгдэгч, хоригдлыг хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэнэ” хэмээн заажээ.

Манай улс дахь шүүн таслах ажиллагааны сүүлийн жилүүдийн практикаас үзвэл шүүгдэгч, ялтныг шүүх хуралдааны танхимаас ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих 461, хорих 401 болон бусад ангиудад хуяглан хүргэх ажиллагаанд учирч буй гол хүндрэлийн шалтгаан нөхцөл нь хүргэгдэгч этгээдийн хорих ялын хугацаа бус, харин бусад нөхцөл байдлууд (тухайлбал: шүүхээс төрийн өндөр албан тушаалтан, нийгмийн зүтгэлтэн, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын удирдагч, нөлөө бүхий гишүүдэд цагдан хорих болон баривчлах, хорих ял оногдуулсан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон) нөлөөлж буй нь хэн бүхэнд тодорхой.

Иймээс хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх ажиллагааны нөхцлийг өөрөөр томъёолох нь зүйтэй.

4. Төслийн 19-р зүйлийн 19.6-г “...хуяглан хүргэх харуул бие хамгаалах тусгай хэрэгсэл, **мэх**, галт зэвсгийг хууль тогтоомжинд заасан журмын дагуу **хэрэглэнэ**” хэмээн өөрчлөн найруулах.

Учир нь гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, манай орны өнөөгийн хууль тогтоомж, практикаас үзвэл “биеийн хүчээр эсэргүүцлийг таслан зогсоох зорилгоор мэх хэрэглэх нь эрх зүйн хувьд бататгагдсан, нөгөө талаас зайлшгүй хуульчлах шаардлагатай харилцаа байдаг.

Мөн “...тусгай хэрэгсэл, мэх, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэж болно” хэмээн хуульчлах нь алба хаагчаас тусгай хэрэгсэл, мэх, галт зэвсэг хэрэглэх, түүнчлэн тэдгээрийг хэрэглэсэн асуудлыг шалган, хянан шийдвэрлэх субъектын хувьд ч субъектив байдлаар нөхцөл байдлыг үнэлэх боломж олгодог тул энэхүү сөрөг хандлагыг таслан зогсооход санал болгож буй томъёолол илүү зохистой гэж үзсэн.

5. Төслийн 19-р зүйлийн 19.7-д “Онцгой тохиолдолд хуяглан хүргэх ажиллагаанд албаны нохой ашиглаж болно” хэмээн заасантай уялдан төслийн “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” гэсэн 3-р зүйлд “Онцгой тохиолдол” гэдгийг нэмж тодорхойлох шаардлагатай.

6. Төслийн 21-р зүйлийн 21.2-т “Хоригдлыг олноор нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд зэвсэгт хүчний анги, салбараас хүн хүчний болон автомашин, техникийн туслалцаа авч болно” хэмээн заажээ.

Олон улсын нийтлэг жишиг, гадаад орнуудын эрх зүйн практик, Монгол улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн зохицуулалт /үзэл баримтлал/-аас үзвэл зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг /эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах явдал/ болон тайван цагт гүйцэтгэх бусад чиг үүрэгтэй төслийн энэхүү заалт нийцэхгүй байна.



7. Төслийн 23-р зүйл хэдийгээр Маршалын албанаас “хорих байгууллагад онцгой нөхцөл үүссэн үед үзүүлэх дэмжлэг”, 29-р зүйл “эрэн сурвалжлах ажиллагаа” гэсэн ялгаа бүхий процессын явцад эдлэх эрх хэмжээг тодотгосон боловч агуулга, зорилгын хувьд адил төстэй ажиллагааныхаа хувьд эсрэг тэсрэг байдлаар тусгагдсан нь алдаатай зохицуулалт болсон гэж үзэж байна.

Учир нь 23.2-т “... гүйцэтгэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаа, зэвсэгт хүчний байгууллагаас нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, тусгай тоног төхөөрөмж, хүн хүчний туслалцаа авч болно” гэсэн бол 29-р зүйлийн 29.1.3-т “... цагдаа, хорих, батлан хамгаалах, дотоодын цэрэг, хилийн алба, тагнуул зэрэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагаас хүн хүч, зэвсэг, автомашин, шатахуун техник хэрэгсэл, түр байрлах байр шаардан гаргуулах, дайчлан ашиглах” хэмээн заажээ.

8. Зэвсэгт хүчин, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын сахилгын шийтгэлийн төрлийг хуульчлахдаа хөнгөнөөс хүндрүү нь жагсаан бичсэн байдаг. Иймд ирээдүйн Маршалын албаны алба хаагчдын цол нь тусгай чиг үүрэг бүхий дээрхи байгууллагын алба хаагчдын цол, цалингийн харьцаатай тодорхой хэмжээгээр дүйцнэ хэмээн үзвэл төслийн 37-р зүйлийн 37.1.2, 37.1.3 дахь хэсгийн байрыг солих шаардлагатай.

9. Төслийн 38-р зүйлийн 2 дахь хэсгийг иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулалттай адилтган өөрчлөх.